

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ПАРК” ОНӨТҮГ-ЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2023 оны 01 дүгээр сарын 05

№

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, иргэдэд хүргэх төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, харьяа байгууллагуудын удирдах ажилтнуудын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэхэд оршино.

1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийг удирдлага болгон нэг талаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, нөгөө талаас Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дарга С.Батжаргал нар цаашид (Удирдах ажилтан), хамтад нь (Талууд) 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

1.3. "Тухайн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас тухайн жилд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, төсөв, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, хугацаа, хариуцах нэгжийг тусгав.

1.4. Талуудын хооронд байгуулсан энэхүү гэрээтэй холбогдох харилцааг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн зохицуулна.

Хоёр. Нийслэлийн Засаг даргын хүлээх үүрэг

2.1. Нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангана.

2.3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, ёс зүй сахилга, хариуцлагыг чангатгах арга хэмжээ авна.

2.4. Харьяа байгууллагуудад төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага, зохицуулалтаар хангана.

2.5. Төрийн худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудад тогтмол зөвлөмж, чиглэл өгч, сургалт, мэдээллээр хангаж ажиллана.

2.6. Төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий харьяа байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээг дүгнэхдээ тухайн удирдах ажилтны иргэдэд цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо, чанар, хүртээмжийг харгалзан дүгнэх, үйлчилгээ үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдах ажилтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллана.

2.7. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн хугацаанд нь олгоно.

2.8. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.9. Ил тод, хэмнэлттэй, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, төсвийн сахилга батыг чангатган, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулж ажиллана.

Гурав. Удирдах ажилтны хүлээх үүрэг.

3.1. Хууль, дүрэм, энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээж, шүүхийн маргаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийг шүүхэд төлөөлж гарсан үр дүнг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өмнө хариуцна.

3.2. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.

3.3. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.

3.4. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, алба хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлнэ.

3.5. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.

3.6. Албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлнэ.

3.7. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээг авна.

3.8. Нийслэлийн удирдлагаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллана.

3.9. Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.

3.10. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангана.

3.11. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.

3.12. Хууль, тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох” тухай 62 дугаар тогтоол, 2020 оны “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” батлах тухай 217 дугаар тогтоол, 2020 оны “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” батлах тухай 218 дугаар тогтоол, 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, 2022 оны “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 448 дугаар тогтоол, 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоол, 2021 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах” тухай 360 дугаар тогтоол, 2022 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 430 дугаар тогтоол, 2022 оны 487, 488, 490, 491 дүгээр тогтоол, 2020 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлах тухай 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолуудыг тус тус хэрэгжүүлж ажиллана.

3.13. Хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал, өгсөн чиг үүргийн биелэлтийг хангаж, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн өмнө хариуцна.

3.14. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллана.

Дөрөв. Гэрээг дүгнэх

4.1. Энэхүү гэрээний биелэлтийг улирал бүр гаргаж, дараа сарын 05-ны дотор Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.

4.2. Гэрээний хавсралт болох “Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний жилийн эцсийн биелэлтийг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны

байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлнэ.

Тав. Гэрээний хариуцлага

5.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүй, гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээг дутуу гүйцэтгэсэн, өмнөх үр дүнг бууруулсан, хүрэх түвшинд хүргээгүй, сахилга, хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан бол Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ.

6.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нэг талдаа бичгээр мэдэгдэнэ.

6.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд 1 хувийг тус тус хадгална.

Долоо. Гэрээ байгуулсан:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

ДОЛГОРСҮРЭНГИЙН
СУМЪЯАБАЗАР

НАЛАЙХЫН БАРИЛГЫН
МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-ЫН
ДАРГА

СОСОРЫН
БАТЖАРГАЛ

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:


НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ
(албан тушаал)

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТАЛСАН:

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

(албан тушаал)

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ


(гарын үсэг)

Тамга

Д.СУМЬЯАБАЗАР/
(нэр)


2024.01.05
(огноо)

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

.....
(гарын үсэг)

Тамга

/ С.БАТЖАРГАЛ /


(нэр)
(огноо)

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
Зорилт 1. Эдийн засгийн зорилтот түвшинг хангах үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулна. НСТ-3.2.							
1.1	Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг үргэлжлүүлэх хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.	-	Хүсэлт гаргах ажлын гүйцэтгэл, хувь	30	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

1.2	Цэвэрлэх байгууламж барих хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах.	-	Хүсэлт гаргах ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
1.3	Дулааны станц барих хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах.	-	Хүсэлт гаргах ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
Зорилт 2. Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг байгуулна. НХТЖҮЧ-4.3.3, НЗДҮАХ-3.2.2.1							
2.1	Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх ажилд хяналт тавин ажиллах.	799.1	Ажлын гүйцэтгэл, хувь	30	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
2.2	"Барилгын материалын бөөний худалдааны төв"-ийн ТЭЗҮ, ХЕТ боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг эхлүүлэх.	Төр хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлэх	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	ХБХГ "НБМҮТП" ОНӨТҮГ
Зорилт 3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ. – Парктай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн акт, дүрмээр тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэх, бодлого боловсруулах, зохицуулах, зохион байгуулах, боловсон хүчнийг бүрдүүлэх, чадавхжуулах, нийгмийн баталгааг хангаж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллана.							
3.1	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах	387.41 Нийслэлийн төсөв	Ажлын гүйцэтгэл, хувь	НАГ-т 2016-2018 оны санхүүгийн тайланг шалгуулж зөрчилгүй санал дүгнэлт авсан.	100	II, IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

3.2	Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
3.3	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
3.4	Паркийн хуулийн этгээдийн хэлбэрийг хуульд нийцүүлэн өөрчлөх санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-II улирал	НБМҮТП ОНӨТҮГ
3.5	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

3.6	Албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтад хамруулах.	-	Сургалтад хамрагдалт, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
3.7	"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын хаягжилт, албан хэрэг боловсруулалтад монгол бичгийг нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулан байгууллагын хаягжилтыг шинэчилсэн байх, албан хаагчдад Монгол бичгийн мэдлэг олгох арга хэмжээг зохион байгуулсан байх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
3.8	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Хэрэгжилт, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
3.9	Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, танилцуулга материал, товхимлуудыг түгээж, хамтарсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

3.10	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
3.11	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих, өмнө нь тарьсан модны арчилгаа, усалгаа хийх.	-	Шинээр тарьсан мод, тоо	Хайлаас 300, 10 улиас, 50 монос тарьсан.	200	II, III улирал	НБМҮТП ОНӨТҮГ
3.12	Хот төлөвлөлт, хот байгуулалтын стандартын барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS 0301B-г таниулах ажлыг зохион байгуулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
3.13	Нийгмийн дэд бүтцийн стандартын дагуу төрийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага UCS 1104B-г хэрэгжүүлэн ажиллах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
3.14	Хог хаягдлын менежментийн стандартын аюултай хог хаягдлын менежмент UCS 1703A, барилгын хог хаягдлын менежмент UCS 1706A, хог хаягдлын устгалын стандарт, устгалын удирдамж UCS 1705A баримт бичгүүдийг паркт байршиж буй аж ахуйн нэгжүүдэд таниулах ажлыг зохион байгуулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

Зорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулна.

4.1	Паркийн нутаг дэвсгэрт шинээр үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах, бүтээн байгуулалтыг эхлүүлэх.	-	Шинээр гэрээ байгуулан ажиллах ААН, тоо	32	37	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.2	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах ажлыг зохион байгуулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	2017 онд 5 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл авсан.	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.3	Паркийн 250 га талбайн ТЭЗҮ-г шинэчлэх хөрөнгө оруулалтыг татах ажлыг эхлүүлэх.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	2014 онд “Арт констракшн” ХХК гүйцэтгэсэн.	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.4	Паркийн 250 га талбайд техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх хөрөнгө оруулалтыг татах ажлыг эхлүүлэх.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	2016 онд “Мецачу” ХХК 120 га талбайд хийсэн.	100	II-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.5	Паркийн цэвэр ус, дулаан хангамж, цэвэрлэх байгууламж, УДДТ-үүдийн барилгын гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийг боловсруулах хөрөнгийн эх үүсвэрийг татах ажлыг зохион байгуулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	Ажлын даалгавар батлагдсан.	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

4.6	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон MNS ISO 45001:2018 стандартыг мөрдөх, төлөвлөгөө гарган ажиллах	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.7	Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийн мөрдлөг болгох.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	2017 онд батлуулсан. Хугацаа дууссан.	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.8	"Таван толгой түлш" ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийг усаар хангах усан хангамжийн байгууламж, усан сан, гүний худгийн барилга байгууламж, шугам хоолойн угсралтын ажлын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	Гүний худгийн барилга угсралтын ажил 50%, шугам хоолойн газар шорооны ажил 60% хийгдсэн.	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ "ТТТ" ХХК
Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт. Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэнэ.							
5.1	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	II улирал	НБМҮТП ОНӨТҮГ
5.2	Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулах.	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

5.3	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
5.4	Албан хэрэг хөтлөлтийн Э-док системд албан хаагчид зөрчил үүсгэхгүй, албан бичгийн норм стандартыг мөрдөх, хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
5.5	Албан хаагчдад үүссэн цаасан болон тусгай төрлийн баримтыг хуваарийн дагуу хүлээн авч байгууллагын архивд бүрдүүлэлт хийх.	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
5.6	2022 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын баримт бичгээ цахим хэлбэрт шилжүүлэн байгууллагын архивын "Archive eDoc" системд хөрвүүлж, нягтлан шалгах ажлыг хийж гүйцэтгэн төрийн архивт цахим нөхөн бүрдүүлэлт хийн захирамжлалын баримтыг цахимжуулсан байх.	-	Ажлын гүйцэтгэл хувь	-	100	I улирал	НБМҮТП ОНӨТҮГ

5.7	Төрийн архивын байнгын хадгалалтад баримт шилжүүлэх ажлын хүрээнд бэлтгэл ажлыг хангаж байнга хадгалах цаасан суурьт болон тусгай төрлийн баримтыг хуваарийн дагуу нийслэлийн Архивын газарт шилжүүлэн Төрийн архивын байнгын хадгалалтад шилжүүлэх.	-	Ажлын гүйцэтгэл хувь	-	100	II-III улирал	НБМҮТП ОНӨТҮГ
-----	--	---	----------------------	---	-----	---------------	------------------